



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

201 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 225 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын албан ажлын хэрэгцээнд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 269,900,000.00 (хоёр зуун жаран есөн сая есөн зуун мянган) төгрөгт багтаан 2 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандaa Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны дүгээр сарын - ны өдрийн  
...дугаар тогтоолын хавсралт



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАР ТАМХИТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ,  
ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 8, хөдөлгүүрийн багтаамж 3956 cc хүртэл (LC200 GX petrol, капон, чанга яригч бүхий тусгай дуут гэрлэн дохио, холбооны станц бүхий)	1	151,000,000.00	151,000,000.00
2	Суудлын тоо 16, хөдөлгүүрийн багтаамж 3456 cc хүртэл (hiace petrol AT)	1	118,900,000.00	118,900,000.00
	Нийт дүн			269,900,000.00 (хоёр зуун жаран есөн сая есөн зуун мянган)